

Яаралтай тусламж судлал

Сорилын зөв хариулт

1-D, 2-A, 3-E, 4-B, 5-C, 6-C, 7-E, 8-D, 9-B, 10-C, 11-B, 12-D, 13-A, 14-B, 15-D, 16-C, 17-D, 18-D, 19-E, 20-B, 21-C, 22-E, 23-D, 24-A, 25-D, 26-C, 27-E, 28-E, 29-C, 30-B, 31-C, 32-C, 33-E, 34-D, 35-A, 36-E, 37-B, 38-D, 39-C, 40-E, 41-D, 42-A, 43-C, 44-B, 45-D, 46-E, 47-D, 48-A, 49-C, 50-D, 51-B, 52-C, 53-E, 54-D, 55-C, 56-E, 57-B, 58-E, 59-D, 60-A, 61-D, 62-C, 63-D, 64-A, 65-B, 66-C, 67-E, 68-A, 69-C, 70-E, 71-B, 72-D, 73-E, 74-B, 75-D, 76-A, 77-D, 78-E, 79-B, 80-D, 81-A, 82-C, 83-E, 84-B, 85-D, 86-A, 87-C, 88-E, 89-B, 90-D, 91-A, 92-C, 93-E, 94-B, 95-D, 96-A, 97-C, 98-D, 99-B, 100-C, 101-D, 102-A, 103-C, 104-E, 105-B, 106-D, 107-E, 108-C, 109-D, 110-A, 111-E, 112-C, 113-D, 114-D, 115-E, 116-D, 117-A, 118-C, 119-C, 120-D, 121-E, 122-E, 123-B, 124-E, 125-C, 126-D, 127-D, 128-E, 129-C, 130-A, 131-C, 132-E, 133-C, 134-D, 135-D, 136-C, 137-D, 138-E, 139-A, 140-D, 141-C, 142-E, 143-B, 144-C, 145-B, 146-E, 147-C, 148-D, 149-E, 150-C, 151-C, 152-D, 153-D, 154-E, 155-D, 156-C, 157-D, 158-A, 159-E, 160-B, 161-A, 162-C, 163-D, 164-D, 165-C, 166-C, 167-D, 168-B, 169-D, 170-C,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E

гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)

1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)

2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (A.)

Зөв, Зөв, Буруу (B.)

Зөв, Буруу, Буруу (C.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Торсадес де поинт бүхий өвчтөнд хэрэглэх эм:

- A. Адерналин
- B. Лидокайн
- C. Кальци глюконат
- D. Магни сульфат
- E. Глюкоз

/2./ Уушигны артерийн эмболийг сэжиглэн цээжний КТГ хийхэдуг эмгэгтэй андуурагддаг хамгийн их тохиолддог эмгэг аль вэ?

- A. Уушигны хатгалгаа
- B. Таамаглаагүй перикардийн шингэн
- C. Шинэ карцинома илрэх
- D. Аортын хуулрал
- E. Пневмоторакс

/3./ Амилуулах суурь тусламжийг хэн үзүүлэх вэ?

- A. Эмч, сувилагч
- B. Эмнэлгийн бүх ажилчид
- C. Насанд хүрсэн бүх хүн
- D. Эмч, сувилагч, цагдаа, онцгой байдлын албан хаагч
- E. Дэргэд нь байгаа хэн ч /бололцоотой болгон/

/4./ Бүдүүн гэдэсний түгжрэлийн элбэг тохиолдох шалтгаан

- A. Наалдац
- B. Хавдар
- C. Хавчигдсан ивэрхий
- D. Цүлхэн
- E. S гэдэс мушгирах

/5./ Холангит бүхий өвчтөнийг холециститээс ялгах хамгийн чухал шинж нь аль нь вэ?

- A. Халууралт
- B. Гиперлипаземи
- C. Шарлалт
- D. Мерфийн шинж
- E. Сийвэнгийн алат, асат ихсэх

/6./ Яаралтай тусламжийн тасагт чихрийн шижингийн нефропатиг оношлох хамгийн мэдрэг шинжилгээ аль нь вэ?

- A. Сийвэнгийн креатинин
- B. Сийвэнгийн мочевин
- C. Шээсний альбумин
- D. Уургийн ачаалалтай сорил
- E. Бөөрний эхо

/7./ Шингэн сэлбэлтэнд тэсвэртэй гипотензитэй өвчтөнд тусламж үзүүлэхээр болов. Та альфа-адренерги бэлдмэл хэрэглэхээр шийдсэн бол дараахаас

алийг хэрэглэх вэ?

- A. Дофамин
- B. Добутамин
- C. Амринон
- D. Изопротренол
- E. Фенилэфрин

/8./ Нойр булчирхайн цочмог үрэвслийн шалтгаан болох нь аль вэ?

- A. Насанд хүрэгсдийн амьсгалын гачаалт хам шинж
- B. Миокардит
- C. Судсан дотор цус түгээмлээр бүлэгнэх
- D. Гүйлгэлт
- E. Нойр булчирхайн хуурамч уйланхай

/9./ Нитроглицерин нь судасны гөлгөр булчинг сулладаг. Бага тунгаар ямар үйлдэл үзүүлэх вэ?

- A. Титэм судсанд
- B. Вен
- C. Том артери
- D. Жижиг артери
- E. Капилляр

/10./ Та амьсгалын аппарат болон интубаци шаардагдаж магадгүй хүнд хэлбэрийн УАБӨ өвчтөнд тусламж үзүүлж байна. Динамик гипервентиляци үүсэхээс сэргийлэх болон хязгаарлахын тулд та юу хийх вэ?

- A. Амьсгалын тоог нэмэгдүүлнэ
- B. Амьсгал гаргалтын урсгалын хурдыг нэмэгдүүлнэ
- C. Амьсгал авалт-гаргалтын харьцааг нэмэгдүүлнэ
- D. Fio₂ - бууруулна
- E. Жижиг диаметр бүхий эндотрахеал гуурсыг байрлуулна

/11./ Титмийн цочмог хам шинжийн талаар зөв ойлголтыг сонгоно:

- A. Тогтворгүй бах болон зүрхний цочмог шигдээс бүхий өвчтөнгүүдийн 10-аас бага хувьд нь гол зовиур нь цээжээр халуу шатах байдаг
- B. Зүрхний ишемийн шалтгаантай байрлал нь тодорхой бус, битүү өвдөлт нь симпатик мэдрэлийн висцерал өвдөлтийн ширхэг цочирсоноос үүсдэг
- C. Хэв шинжит зүрхний бах нь дасгал хөдөлгөөнд үе үе сэдэрдэг ба 5 минутаас удаан үргэлжилдэггүй өвдөлт нь 90%-д өвчүүний араар өвдөнө, 50%-д дамжих өвдөлт илэрдэггүй ба нитроглицеринд өвдөлт намддаг
- D. Тайван үед илрэх зүрхний бах эсвэл бахын өвдөлтийн шинж чанар нь өөрчлөгдөх нь дасгалаар сэдээгддэг бахтай харьцуулахад зүрхний гэнэтийн үхлээр нас барах эрсдэл бага
- E. Принцметалны бах нь зүрхний дамжуулалтын алдагдлын улмаас үүсдэг ба дасгал хөдөлгөөнд сэдэрч нитроглицеринд тэсвэртэй байдаг.

/12./ Жирэмсэн үед эхлээд эхийн цусанд ямар даавар ялгарах вэ?

- A. Пролактин
- B. Эстроген
- C. Ихсийн лактоген
- D. Ихсийн гонадотрофин
- E. Бүгд

/13./ Ухаангүй хүнд сийвэнгийн чихэр үзэх боломжгүй бол глюкоз хэдэн граммыг тарьдаг вэ?

- A. 25гр
- B. 50гр
- C. 60гр
- D. 40гр
- E. 10гр

/14./ Хоол боловсруулах дээд замын цус алдалтын түгээмэл шалтгаан?

- A. Улаан хоолойн венийн өргөсөл
- B. Ходоод, 12 хуруу гэдэсний шарх
- C. Маллор-Вейссийн хамшинж
- D. Ходоодны салстын улайлт
- E. Артер венийн мальформац

/15./ Төрсөний дараа нярайн булчингийн тонус сайн ,бүх мөч хөдөлгөх ба ЗЦТ =90, чанга дуугаар уйлж, найталгаж арьсны өнгө нь бүх биеэр ягаавтар байсан бол нярайг Апгарын оноогоор

- A. 6
- B. 7
- C. 8
- D. 9
- E. 10

/16./ Доорхоос аль нь байхад венийн судасны тромбоэмболи үүсэх харьцангуй эрсдэл хамгийн их вэ?

- A. Таргалалт
- B. Хавдар
- C. С уургийн дутагдал
- D. Нас > 50
- E. Амаар контрацептив уух

/17./ Хөлдсөн мөчийг дулаацуулах хамгийн сайн арга нь:

- A. Аажим гэсгээх арга хэмжээ авах бөгөөд мөснөөс эхэлж олон дараалалтай ванан дүрж дулаацуулна
- B. Хүчээр дулаацуулдаг төхөөрөмж хэрэглэнэ. Жнь: Байр-Хуггерын аппарат
- C. Хэсэг газарт үрж массаж хийнэ
- D. 40–42°C усанд шууд дүрнэ
- E. Халуун дөлөнд барьж халаана

/18./ Сургуулийн өмнөх нас хэд вэ?

- A. 3-6 нас
- B. 3-5 нас
- C. 4-6 нас
- D. 4-5 нас
- E. 4-7 нас

/19./ 39 настай эмэгтэй амьсгалын цочмог дутагдалтай, рентгенд зурагт уушигны завсрын тархмал нэвчдэстэй байв. Бодит үзлэгээр халууралттай ба төвдөө цэврүүтэй тойрсон улаймал тууралттай байв. Түүний халдварын шалтгаан аль нь байх магадлалтай вэ?

- A. Микоплазмын уушигны хатгалгаа
- B. Уушигны саркойдоз
- C. Легионеллийн хатгалгаа
- D. Сорогдлын хатгалгаа
- E. Салхин цэцгийн уушигны хатгалгаа

/20./ Цочмог холециститыг оношлох хамгийн мэдрэг болон өвөрмөц шинжилгээ аль нь вэ?

- A. Амаар холецистограмм хийх
- B. HIDA радиоизотоп шинжилгээ
- C. Хэвлийн эхо
- D. Хэвлийн рентгэн зураг
- E. Халуурах, билирубин болон шүлтлэг фосфатаза ихсэх гурвал шинж илрэх

/21./ Хүчдэлт пневмотораксын үед зайлшгүй шаардлагатай нь:

- A. Хүчилтөрөгч эмчилгээ
- B. Зохиомол амьсгал
- C. Цээжний гялтангийн хөндийд хатгалт хийх
- D. Зүрхэнд нөлөөлөх бэлдмэл хийх
- E. Судас нарийсгагч хэрэглэх

/22./ Шархлаат колитын үед үүсэх хамгийн аюултай хүндрэл:

- A. Их хэмжээгээр цус алдах
- B. Чацархайн ишеми
- C. Уураг-калор алдах хам шинж
- D. Малабсорбци ба электролитын алдагдал
- E. Бүдүүн гэдэсний хоруу тэлэгдэл

/23./ Зүрх зогссоны дараа цусны эргэлт эргэн сэргэсэн үед аль эмчилгээ нь хамгийн үр нөлөөтэй байдаг вэ?

- A. Глутамат антагонист
- B. Кальцийн суваг хориглогч
- C. Чөлөөт радикалыг багасгах
- D. Гипергликемийг инсулинаар хянах

- Е. Натрийн суваг хориглогч
- /24./ Зүрхний дутагдлын үед гликозид эмчилгээний хамгийн чухал нөлөө аль нь вэ:
- А. Тосгуурын жирвэлзэлд ховдлын хариу урвалыг хянана.
 - В. Пароксизмал тосгуурын тахикардийг хориглож хянах эсвэл хажуугийн хэмнэл хурдсах
 - С. Зүрхний булчингийн агшилтыг ихэсгэж ингэснээр зүрхний төрөлхийн гажгийн шинж тэмдгийг бууруулдаг
 - Д. Зүрхний булчингийн агшилтыг сайжруулж нас баралтыг бууруулна
 - Е. Зүрхний булчингийн агшилтыг сайжруулах, зүрхний төрөлхийн дутагдалтай үед зүрхний цохилтыг бууруулна
- /25./ Зөв хамааралтайг сонго:
- А. Гипокальцеми ба гликозид - зүрх зогсолт
 - В. Гипермагнези - өргөн QRS, PR сегмент болон QT интервал удаашрах, ST-сегмент буух нь Т-шүд сөрөг болох
 - С. Бөөрний дутагдал ба ходоодны шарх нь кальцийн суурь бүхий антацидаар эдгэрдэг - гүний шөрмөсний рефлекс алдагдсанаар гипотензи болон амьсгалын дутагдал хүрнэ.
 - Д. Бөөрний дутагдал ба зүрх зогсолт - таамгаар кальци хлорид судсаар хийнэ
 - Е. Гипермагнези ($>10 \text{ mEq/mL}$) - гемодиализ хийнэ
- /26./ Хахсан хүний хүчтэй ханиаж байгаа үед та юу хийх вэ?
- А. Толгой уруу нь цохино
 - В. Амыг нь ухах
 - С. Үргэлжлүүлэн ханиахыг дэмжинэ
 - Д. Ус өгч залгиулна
 - Е. Дээрхийн аль нь ч биш
- /27./ Цочмог гүйлгэлт үүсэх хамгийн түгээмэл шалтгаан:
- А. Хоол хүнсний үл зохицол
 - В. Хордох
 - С. Бактерийн халдвар
 - Д. Шимэгч
 - Е. Вирусын эмгэг
- /28./ Удаан үргэлжлэх гипоксийн улмаас үүсэх хүндрэл:
- А. Уушигны судас тэлэгдэх
 - В. Уушигны орой руу урсах уушигны цусан хамгамжийн харьцаа алдагдах
 - С. Титмийн судас агших
 - Д. Баруун ховдлын диастолын төгсгөлийн даралт буурах
 - Е. Эргэлдэх цусны хэмжээг ихэсгэж зүрхний өмнөх ачаалалыг нэмдэг
- /29./ Давтан төрөгчид төрлөг хэдэн цаг үргэлжлэх вэ
- А. 3-5 цаг

- B. 5-7 цаг
 - C. 8-12 цаг
 - D. 13-18 цаг
 - E. 19-24 цаг
- /30./ 2 гр магни хийхийн тулд 25% уусмал хэдэн мл хийх вэ?
- A. 10мл
 - B. 8 мл
 - C. 16 мл
 - D. 20 мл
 - E. 4 мл
- /31./ Чихрийн шижингийн кетоацидозын талаар зөв ойлголтыг сонго:
- A. ЧШ-ийн кетоацидоз болох шалтгаан нь идиопатик
 - B. Өвчтний ухаан санааны түвшин нь ацидоз болон гипергликемийн хүндрэлийн зэрэгтэй шууд хамааралтай
 - C. Сийвэнгийн глюкозын түвшин 180 мг/дл ихсэх болгонд сийвэнгийн натрийн хэмжээ ойролцоогоор 5 мЭв/мл буурдаг
 - D. Глюкагон болон бусад гормонууд ЧШ-ийн кетоацидоз үүсэхэд хамааралгүй
 - E. Хэвийн дулаантай өвчтөн бүрт халдварыг илрүүлэх шаардлагагүй
- /32./ АлАТ-ийн идэвхижил ихсэх нь ямар эмгэгийн үед оношлогооны ач холбогдолтой вэ?
- A. Зүрхний шигдээс
 - B. Бөөр болон булчингийн гэмтэл
 - C. Элэгний үрэвсэл
 - D. Элэгний хатуурал
 - E. Цус задрал
- /33./ Шоктой өвчтөнг эмчлэх эмчилгээний зорилт
- A. Төвийн вений даралтыг хэвийн болгох
 - B. Эдийн перфузийг хэвийн болгох
 - C. Шээсний гарцыг 0.5–1.0 мл/кг/цаг
 - D. Артерийн дундаж даралтыг 65 мм МУБ дээш
 - E. Дээрх бүгд зөв
- /34./ Мухар олгойн цочмог үрэвслийн эмнэл зүйн оношилгоонд доорхоос аль нь хамаарах вэ?
- A. Хэвийн халуун
 - B. Хэвийн халуун
 - C. Өлсөх
 - D. Гэнэт хэвлийгээр өвдсөний дараа бөөлжих
 - E. Суулгалт
- /35./ Пульсгүй цахилгаан идэвхижил бүхий өвчтөнд амилуулах тусламж үзүүлэх үед таны эмчилгээний сонголт:

- A. Шингэн сэлбэх
- B. Судсаар кальци хлорид
- C. Судсаар лидокайн
- D. Судсаар кальци глюконат хийх
- E. Судсаар нитроглицерин

/36./ Хордолтын үед илрэх шинж тэмдэг болон эмчилгээг зөв хамааралтайг сонго

- A. Аммонын хордлого → Амьсгалын доод замын шинж тэмдэг
- B. Фосгений хордлого → Амьсгалын дээд замын эмгэг
- C. Сульфидын хордлого → метилен хөх эмчилгээ
- D. Хлортхүхрийн хүчлийн хордлого → ус уулгах
- E. Метал шаталтын утаанд хордох → толгой өвдөх, ханиалгах, халуурах, чичрүүлэх, болон булчингаар өвдөх

/37./ Цочмог чацархайн ишеми үүсэх зонхилох шалтгаан:

- A. Артерийн тромбоз
- B. Артерийн эмболи
- C. Венийн бөглөрөл
- D. Хэт бүлэгнэлтийн байдал
- E. Судасны бөглөрөлт бус эмгэг

/38./ Уушгинд аспирацийн хүндрэл тохиолдвол доорхоос аль нь илүү ач холбогдолтой вэ?

- A. Саармагжуулах шүлтлэг уусмалыг мөгөөрсөн хоолойруу цацах
- B. Даавар эмчилгээ
- C. Антибиотик урьдчилан сэргийлэлт
- D. Уушиг дурандаж угаах
- E. Дээрх бүгд

/39./ Тромбоз бүхий шамбарамтай өвчтөн:

- A. “Резинен боолтоор чангалах” эмчилгээ хийлгэх шаардлагатай
- B. Зүслэг хийлгэж , урсгуур тавих ихэнх тохиолдолд хэрэглэнэ
- C. Өөлж авах ажилбар хийлгэж дараа нь гэртээ зориулалтын уусмалд дүрэх
- D. Дахихаас сэргийлж манжин идэхээс зайлсхийх
- E. Опойдын төрлийн өвчин намдаагчийг өтгөн хаталт үүсгэдэг учраас хэрэглэхгүй

/40./ Аортын хуулрал болон аневризмын талаарх зөв хариултыг сонго:

- A. Цээжний хөндий дахь аортын хуулрал нь проксимал хэсгээс бронхиоцефаликийн эхлэл хэсэг хүртэл үргэжилсэн бол ДеБакей ангилалаар 3-р хэлбэрт ангилагдана
- B. Аортын хуулралын хамгийн түгээмэл илрэлт нь санамсаргүй байдлаар цээжний рентген зураг авахад илэрдэг
- C. Цээжний хүчтэй өвдөлт хөл эсвэл хэвлий рүү дамжих нь аортын

хуулралын үед илрэх хамгийн түгээмэл илэрдэг зовиур юм.

D. Аортын аневризм нь аортын хуулралаас 3 дахин их тохиолддог.

E. Аортын аневризимтай харьцуулхад аортын хуулрал бүхий өвчтөнгүүд ихэвчлэн яаралтай хагалгаанд ордоггүй

/41./ Та цахилгааны утас хазаж тогонд цохиулсан 3 настай охиныг үнэлэх гэж байна. Тэр уйлах бөгөөд уруул орчим цэврүү гарсан ба завьж орчмоор харалсан шархтай байв. Хамгийн хурдан тохиолдох ямар хүндрэл үүсэж болох вэ?

A. Ам орчим хавдах удааширсанаас амьсгалын замын хүндрэл гарна

B. Эрүүний хугарал эсвэл шүд

C. Зүрхний хэм алдагдал

D. Цус алдалт

E. Катаракт

/42./ Зүрхний пейсингийн талаарх зөв ойлголтыг сонго:

A. Пейсмейкерийг ихэвчлэн баруун талын дотор гүрээний венээр оруулдаг

B. Арьсан доор байрлалтай пейсингийг өвчтөнд хүрэх хэрэгцээ гарсан үед зогсооно

C. Пульсгүй өвчтөнд венийн судсаар пейсмейкер оруулах нь эсрэг заалттай

D. Өвчтөн ухаан орох үед гадна пейсингийг аль болох эрт зогсоох хэрэгтэй

E. Гадна пейсмейкерын наалтыг өвчтөний зүрхний орой болон суурь дээр байрлуулах хэрэгтэй

/43./ 49 настай бөөр орлуулах эмчилгээний хамааралтай өвчтөн бүх бие суларсан гэсэн зовиуртай ирэв. ЗЦБ-т Т шүд өндөр, QRS комплекс өргөн болсон байв.Эхний тохиромжтой эмчилгээ юу вэ?

A. Судсаар глюкоз, инсулин хийх

B. Судсаар натрийн бикарбонат хийх

C. Судсаар кальци глюконат хийнэ

D. Сальбутомолаар амьсгалуулна

E. Амаар эсвэл шулуун гэдсээн натрийн полистирен сулфонат өгнө

/44./ Тайван үед хөнгөн зэргийн баруун зүрхний дутагдалтай өвчтөн:

A. АД бага байх

B. Төвийн венийн даралт их байна.

C. Зүрхний шахалтын эзэлхүүн буурна.

D. Зүрхний эргэн дүүрэлт ихсэх

E. Зүүн тосгуурын даралт ихсэх

/45./ ЗЦБ-т V3, V4 холболтонд ST- сегмент өргөгдсөн бол ямар артери бөглөрсөн байж болох вэ?

A. Left circumflex

B. Right anterior descending

C. Right circumflex

- D. Left anterior descending
- E. Right, Left anterior descending

/46./ Угаарын хийнд хордолтын талаарх зөв ойлголтыг сонго?

A. Арьс болон салст нь тоорын улаан болох нь хамгийн түгээмэл тохиолддог мэдрэг шинж тэмдэг юм

B. Дотор муухайрах, бөөлжих, суулгах нь гастроэнтерит оношоор оношлогдох эрт үеийн шинж болдог

C. СОHb (карбоксигемоглобин) түвшин тамхичдад 10-20% илэрдэг

D. Нүд улайх нь мэдрэг биш эсвэл эрт үед илрэхгүй

E. Талбар дээр шинжилсэн СОHb түвшин эмнэлзүйтэй шууд хамааралтай байдаг

/47./ Сийвэнгийн К багасах шалтгаанд аль нь хамаарахгүй вэ?

A. Их шээх

B. Бөөлжих

C. Хоол тэжээлээр орох К-ийн хэмжээ багасах

D. Их хөлрөх

E. Чацга алдах

/48./ . Насанд хүрсэн хүн яаралтай тусламжийн тасагт гипогликеми болж ирэх хамгийн түгээмэл 2 шалтгаан:

A. Диабет ба архины хэрэглээ

B. Диабет ба элэгний дутагдал

C. Диабет ба үжил

D. Элэгний дутагдал ба үжил

E. Элэгний дутагдал ба архины хэрэглээ

/49./ Таны өвчтөн ухаангүй, пульсгүй байгаа бөгөөд торсадо де поинт хэм алдалт байна гэж үнэлээд дефибрилятоор 1 удаа цохиулсан. Та доорх эмүүдээс алийг хийх вэ?

A. Sodium bicarbonate

B. Atropine

C. Magnesium sulfate

D. Calcium chloride

E. Epinephrine

/50./ Гипертермийн талаарх зөв ойлголтыг сонго:

A. Дулаанд цохиулалтын тодорхойлолт нь биеийн дулаан 38.9°C их болохоор хэлнэ

B. Тархинд цус харвах үед гипертермигээс илүү гипотерми болох нь их байдаг

C. Нейролейптик малигнант синдром болон хорт халууралт нь үйл туйлшруулагч паралитикт хоёулаа эмчлэгддэг

D. Нейролейптик малигнант синдром болон хорт халууралт нь хоёулаа дантроленд эмчлэгддэг

- Е. Нейролейптик нь удамшдаг эмгэг юм
- /51./ Ховдлын тахикардитай захад судас тэмтрэгдэхгүй өвчтөнд кордарон хэдэн мг хийх вэ?
- А. 150 мг
 - В. 300 мг
 - С. 1 мг/кг
 - Д. 1.0- 1.5мг\кг
 - Е. 100 мг
- /52./ ЧШ Кетоацидоз бүхий өвчтөнд Куссмаулын амьсгал үүсэх шалтгаан:
- А. Цусны сахар ихсэх нь амьсгалын төвийг идэвхжүүлдэг
 - В. Сийвэнгийн хүчилшил нь захын хеморецепторыг идэвхижүүлдэг
 - С. Сийвэнгийн устөрөгчийн ион ихсэх нь амьсгалын төвийн рецепторыг идэвхижүүлдэг
 - Д. Эсийн гаднах шингэний хэмжээ буурах нь бикорбонатын реабсорбцийг ихэсгэдэг
 - Е. Инсулин нь амьсгалын төвийг шууд дарангуйлдаг
- /53./ БУЭ хэн хийх вэ?
- А. Зүрхний эмч нар
 - В. Яаралтай тусламжийн, эрчимт эмчилгээний эмч
 - С. 103-н эмч
 - Д. Зүрхний ангиографийн эмч
 - Е. Боломжтой бол дээрх бүгд
- /54./ Амьсгалын дутагдалтай, амьсгалахад цээж намалзсан, гэмтсэн өвчтөнд тусламж үзүүлж байна. Өвчтөнд зохиомол амьсгал өгөх заалт нь аль вэ?
- А. Амьсгалын тоо > 25/мин
 - В. Амьсгалын тоо < 12/мин
 - С. $FiO_2 > 0.5$ өгч байхад $PaO_2 < 70$ mmHg байх
 - Д. $FiO_2 > 0.5$ өгч байхад $PaCO_2 > 55$ mmHg байх
 - Е. Цулцан-артерийн хүчилтөрөгчийн градиент > 350
- /55./ Титмийн артерийн эмгэгийн эрсдэлт хүчин зүйлд аль нь багтдаггүй вэ?
- А. Эр хүйс
 - В. Холестрол их байх
 - С. Дааврын бус үрэвслийн эсрэг эм
 - Д. Чихрийн шижин
 - Е. Тамхи татах
- /56./ Үрэвслийн эсрэг дааврын бус эмийн гаж нөлөө аль нь вэ?
- А. Дотор муухайрах, бөөлжих, хэвлий өвдөх
 - В. Толгой өвдөх, зан төрхийн өөрчлөлт, халдварын бус менингит
 - С. Таталт
 - Д. Бодисын солилцооны ацидоз ба бөөрний цочмог дутагдал
 - Е. Дээрх бүгд

/57./ Ротавирусаар үүсгэгдсэн суулгалтаар өвдөх хамгийн өртөмхий бүлэг аль нь вэ?

- A. Нярай
- B. Сургуулийн өмнөх насны хүүхэд
- C. Сургуулийн насны хүүхэд
- D. Насанд хүрэгч
- E. Настан

/58./ 10-р ангийн нэг ангийн 3 сурагч мухар олгойн шинжтэй иржээ . Тэдгээр сурагчдад баруун доор байрлалтай хэвлийн өвдөлт, дотор муухайрах, бөөлжих, бага зэрэг халуурах шинжтэй байв. Та үүнийг маш сонин тохиолдол гэж үзэж нутгийн яаралтай тусламжийн хэсэг рүү залгаж лавлахад мөн тийм шинжтэй 6 хүүхэд байсан ба 2 нь аль хэдийн мухар олгойн хагалгаанд оржээ. Та мухайр олгойн үрэвслээс илүү ямар эмгэгээр халдварлагдсан гэж үзэх вэ?

- A. Bacillus cereus
- B. E. coli 0157:H7
- C. Cryptosporidiosis
- D. Group D Streptococcus
- E. Yersinia enterocolitica

/59./ Хүүхдийн зүрх зогсох голлох шалтгааныг дурдана уу.

- A. Уушгины гаж хөгжил
- B. Хүүхдийн уушгины төрөлхийн гаж хөгжил
- C. Зүрхний гэмтэл
- D. Хүчилтөрөгчийн дутмагшил
- E. Дээрх бүгд зөв

/60./ Сөрөг Т шүд нь ихэвчлэн ямар шалтгаанаас үүсэх вэ:

- A. Ховдлын реполяризаци нь эндокардиас эпикардийн чиглэлд үүсэх
- B. Ховдлын реполяризаци нь эпикардаас эндокардийн чиглэлд үүсэх
- C. Ховдлын деполяризаци нь эндокардиас эпикардийн чиглэлд үүсэх
- D. Ховдлын деполяризаци нь эпикардаас эндокардийн чиглэлд үүсэх
- E. АВ зангилааны дамжуулалтын алдагдлаас

/61./ Гүйцэд нярай хүүхэд гэж ?

- A. 0-27 хоног
- B. 0-60 хоног
- C. 0-30 хоног
- D. 0-28 хоног
- E. 0-25 хоног

/62./ Жирэмсний эхний гестозын үед аль шинж нь байхгүй вэ?

- A. Биеийн жин буурах
- B. Шээсэнд ацетон гарах
- C. Артерийн даралт буурах

- D. Толгой өвдөх
- E. Бага зэрэг халуурах

/63./ Цахилгаан нь:

- A. Шулуун гүйдэл
- B. Хувьсах гүйдэл
- C. Хувьсах болон шулуун гүйдлийн холимог
- D. Хувьсах болон шулуун гүйдлийн аль нь ч биш боловч нэг чиглэлтэй цахилгаан урсгал юм
- E. Цахилгаан хэлхээний онолоор тайлбарлагддаггүй

/64./ Хэвийн байрласан ихэс цагаас урьтаж ховхрохын эмнэл зүйн эхний шинж тэмдэг

- A. Хэвлийгээр өвдөнө, барихад умай өвчтэй.
- B. Цус алдатын дайрлага.
- C. Ургийн бүтэлт
- D. Базлалт ихэсдэг.
- E. Ургийн шингэн гарна.

/65./ Өвдөлттэй, цус алдаж байгаа шулуун гэдэсний эмгэгийн түгээмэл шалтгаан доорхоос аль нь вэ?

- A. Дотор шамбарам
- B. Шулуун гэдэс урагдах
- C. Гадна шамбарам
- D. Бүдүүн гэдэсний цүлхэн
- E. Шулуун гэдэсэнд гадны биет орох

/66./ Кроны өвчний талаарх зөв ойлголтыг сонго:

- A. Кроны өвчин үүсэхэд удамшлын хүчин зүйл хамааралгүй
- B. Хүүхэд болон насанд хүрэгчдэд эмнэлзүй эхлэх болон эмчилгээ нь ялгаатай байдаг
- C. Нарийн гэдэс болон бүдүүн гэдэс эсвэл 2 ууланг хамарсан гэсэн 3 хэлбэртэй
- D. Гэдэсний өнгөц давхаргыг хамарсан үргэлжилсэн гэмтэл үүсгэдэг
- E. Сэтгэцийн хүчин зүйл нь үүсгэх чухал хүчин зүйл болно

/67./ 25 настай эрэгтэй архи их хэмжээгээр ууж , гадаа гудамжнаас унтаа байдалтай олдож ЯТТ-д хүргэгдэж ирэхэд тэрээр ухаангүй ба цулын дулаан 27.8°C ба пульс нь 40удаа/мин байв. Дараахаас аль нь үнэн бэ

- A. Өвчтөнийг дулаацтал CPR хийнэ
- B. QRS бүрдлийн төгсгөл хэсгийн өргөгдөл нь тавилан мууг заана
- C. Брадикардиг судсан дотуур пейсмейкер тавьж эмчилнэ
- D. Гипотермитэй пульсгүй өвчтөнд гадна цус эргэлтийн аппарат эмчилгээ үр дүнгүй
- E. Гипотермитэй өвчтөнд шингэний хэмжээ буурсан байдаг

/68./ ЗЦБ-т дараалласан 2 болон түүнээс дээш холболтонд ST- сегмент

өргөгдсөн бол

- A. Зүрхний шигдээс
- B. Зүрхний цусан хангамжийн дутагдал
- C. АВ зангилааны бүтэн хориг
- D. Гиперкалиеми
- E. Митрал регургитаци

/69./ Судасны системийн ямар хэсэг нь судасны эсэргүүцлийг бүрдүүлэх вэ?

- A. Аорта
- B. Дунд калибрийн артери
- C. Артериол
- D. Капиляри
- E. Вен

/70./ Амьсгал хангалттай байгааг тодорхой илтгэх үзүүлэлт нь юу вэ?

- A. Амьсгалын эзэлхүүн
- B. Амьсгалын минутын эзэлхүүн
- C. Амьсгалын тоо
- D. Үхмэл зайг тодорхойлох
- E. PaO_2 ба $PaCO_2$

/71./ Тосгуурын жирвэлзэлтэй өвчтөн пульс 180 удаа\мин, АД 70/50 мм МУБ болсон ухаан санааны байдал муудсан. Синхрон кардиоверсийг хэдэн Джоулаар эхлэх вэ?

- A. 50 J
- B. 100 J
- C. 200 J
- D. 360 J
- E. 160 J

/72./ Төрлөгийн II үе эхэлж байгаа шинжийг хэлнэ үү

- A. Дүлнэ
- B. ургийн шингэн гарна
- C. Ургийн толгой цухалзана
- D. Умайн хүзүү бүрэн нээгдэнэ
- E. Бүгд

/73./ 58 настай эрэгтэй залгихад өвдөнө гэсэн зовиуртай ирэв. Тэрээр ярих үедээ 2 эсвэл 3 удаа шүлсэндээ хахдаг өвөрмөц зуршилтай байв. Тэрээр түгшсэн байдалтай байсан бол энэхүү өвчтөнд улаан хоолойн эмгэгийн байрлал хаана байх магадлал их вэ?

- A. Ходоод улаан хоолойн залгаас
- B. Бронхын зүүн ерөнхий салаанд
- C. Духны бор гадар
- D. Тархины баганы 3 хос мэдрэлийн бөөмөнд
- E. залгиурын бөгж мөгөөрсөний түвшинд

/74./ Мухар олгой бүхий өвчтөнд илрэх хамгийн түгээмэл илрэх шинж:

- A. Пиоури
- B. Дотор муухайрна бөөлжинө гэхдээ гүйлгэхгүй
- C. Халуурна $>39.4^{\circ}\text{C}$
- D. Лейкоцитоз $> 20,000$
- E. Хэвлийн радиографид аппендоколит илрэх

/75./ Гиповолемийн үед илрэх гол шинжүүдийн нэг?

- A. Биеийн халуун буурах
- B. Арьс хөхөрч тарлантах
- C. Амьсгаадах
- D. Шээс багадах
- E. Зүрхний цохилт цөөрөх

/76./ Вений тромбоземболийн талаарх зөв ойлголтыг сонго:

- A. Уушигны эмбол нь шилбэний венийн судаснаас ихэвчлэн үүсдэг
- B. Уушигны эмболийн үед илрэх хамгийн түгээмэл шалтгаан нь цустай цэр гарах
- C. Уушигны эмболийн үед тохиолддог хамгийн их тохиолдох шинж нь тахикарди
- D. Уушигны эмболийн ихэнх тохиолдол нь шалтгаан тодорхойгүй
- E. "Вентилиаци-перфузи харьцаа хэвийн байх нь оношийг үгүйсгэнэ

/77./ Хэвийн үед зүрхний хөтлөгч хэмийн сэрэл хаанаас үүсэх вэ?

- A. Пуркиньегийн ширхэг
- B. Атриовентрикуляр зангилаа
- C. Ховдол хоорондын таславч
- D. Синусын зангилаа
- E. Гиссын багц

/78./ 37 настай эмэгтэй өмнө олон архаг өвчний анамнезтэй бөгөөд одоо цочмог холециститээр оношлогдов. Та холестролын чулуу үүссэн гэвэл өмнө нь ямар өвчнөөр өвдсөн байж болох вэ?

- A. Гипертриглицеридеми
- B. Гиперхолестролеми
- C. Өмнө нь хүхэр агуулсан антибиотик ууссаны улмаас G6PD дутагдал үүсэх
- D. Хадуур эс
- E. Цутгалан гэдсийг мэс заслаар тайрах

/79./ Зүрхний гаралтай шокын үед

- A. Пропронолол
- B. Допамин
- C. Дигоксин
- D. Изадрин
- E. Эфидрин

/80./ Дараах дүрс оношилгооны шинжүүдээс аль нь зөв уялдсан байна вэ?

А. 34 настай эрэгтэйн таглаа мөгөөрсний хэсэгт эрхий хурууны дардсын шинж илэрсэн -хэлэн доорх буглаа

В. Хүүхдэд С3-ын дээрх С2 урд хэсгийн хэлбэр өөрчлөгдөх - тулгуур үений хугарал

С. “Сүмийн орой” -хэлбэрийн цагаан мөгөөрсөн хоолой хүүхдэд илрэх - эпиглотит

D. нярайд ямар нэг эмнэл зүйн шинж тэмдэггүй, хүзүүний нугаламын ойролцоох зай хавагнасан - артифакт

Е. Нярай хүүхдийн гэдсэн дотор хий харагдах гэдэс чихэлдэж түгжрэх

/81./ 54 настай эрэгтэй яаралтай тусламжийн тасагт цээжээр өвдсөн зовиуртай ирэв. Бодит үзлэгт түүний гүрээний вен өргөссөн байсан ба уушиг цулцангийн амьсгалтай, ЗЦБ-т доод ханы цочмог шигдээс илэрсэн, артерийн даралт90/60 мм МУБ байв. Доорхоос аль эмчилгээг хийх вэ?

А. Судсаар шингэн сэлбэх

В. Норадерналин

С. Дофамин

D. Несиритид

Е. Нитрофурсид

/82./ Үжлийн гаралтай шокийн байдалтай өвчтөнд нэн тэргүүнд сонгон авах эмчилгээний арга нь:

А. Цус шүүх

В. Коллойд сэлбэх

С. Кристаллойд уусмал сэлбэх

D. Допамин

Е. Норадреналин

/83./ Амьсгалын алкалоз бүхий өвчтөнд зохиомол амьсгалын хамгийн эхний сонголт

А. Булчин суллах эм хэрэглэх

В. Үлдэгдэл эзэлхүүнийг ихэсгэх

С. Тайвшруулах

D. Амьсгалын тоог ихэсгэх

Е. Амьсгалын тоог бууруулах

/84./ 4 настай хүү авто ослын улмаас хүнд хэлбэрийн амьсгалын гачаалт хам шинжид оржээ. Тэр машинаас шидэгдэж нүүр болон толгойдоо хүнд гэмтэл авсан.Түүний амьсгалын замыг хэрхэн чөлөөлөх вэ?

А. Тохирсон хэмжээ бүхий төвөнхийн маск тавьж сорогдлын хатгаанаас сэргийлнэ

В. Интубаци тавих эсвэл амьсгал өгж чадахгүй бол мэс заслын аргаар крикотреотоми хийхээс илүү зүүт крикотреотоми хийнэ

С. Амьсгалын замыг бүтцүүдийг бүрэн харахын тулд хүзүүг тэнийлгэнэ

D. Тохирсон хэмжээтэй эндотрахеал гуурсыг хамарзалгиураар оруулах аргаар баримжаалж интубаци тавина

Е. Гэмтлийн хурц үе учраас сукцинилхолин хэрэглэхээс зайлсхийнэ /85./ 70 настай эмэгтэй хэсэг хугацааны туршид хэвлийн доод хэсгээр өвдөх болон их хэмжээгээр шулуун гэдсээр цус алдаж байна гэсэн зовиуртай ирсэн. Хамар ходоодоор зонд оруулахад цэс байсан боловч цус байгаагүй байна. Тэгвэл түүний онош аль нь байх хамгийн өндөр магадлалтай вэ?

- A. Эвэрхий
- B. Ходоодны шарх
- C. Дотор гемморрой
- D. Дивертикулос
- E. Чацархайн ишеми

/86./ Геморрагийн шоктой өвчтөнд тархины цусан хангамж хэрхэн хадгалагдах вэ ?

- A. Ауторегуляци
- B. Реактив гиперемии
- C. Идэвхитэй гиперемии
- D. Бодисын солилцоог ихэсгэж
- E. Шумбах рефлекс

/87./ Захын судасны бөглөрөлтэй өвчтөнд эмболийн үүссэн гол байршил:

- A. Гол судас
- B. Гуяны артери
- C. Зүрх
- D. Чацархайн артери
- E. Тахимын артер

/88./ Зүрх зогссон өвчтөнд венийн судсанд хүрц авахад аль нь хамгийн бага сонгодог судас вэ?

- A. Захын тохойн хонхрын вен
- B. Эгмэн доорх вен
- C. Гүрээний дотор вен
- D. Шууны вен
- E. Гуяны вен

/89./ Титмийн цочмог хам шинжтэй өвчтөнд нитроглицеринийг хэрэглэсэнээр гарах шинж тэмдгийн сайжрал нь түүний аль үйлдэлтэй холбоотой вэ?

- A. Уушигны артерийг агшаах
- B. Зүрхний өмнөх ачаалалыг бууруулна
- C. Дараах ачаалалыг бууруулна
- D. Титэм судсыг агшаах
- E. Инотропик дэмжлэг

/90./ Хэв шинжит бус уушгины хатгалгааны эмчилгээнд доорхоос багтахгүй нь аль вэ?

- A. Erythromycin
 - B. Azithromycin
 - C. Tetracycline
 - D. Penicillin эсвэл Cephalosporin
 - E. гуурсан хоолой өргөсгөгч, ханиалга дарах
- /91./ Ихэс төвөөрөө түрүүлсэн үед төрөлт шийдвэрлэх хамгийн зохистой арга
- A. Кесар хагалгаа хийх
 - B. Эх барихын хавчуур тавих
 - C. Ургийн шингэний хальс цоолох
 - D. Ихсийг цоолж, ургийн түрүүлсэн хэсгээс Мюзогийн хавчуураар барьж ачаа зүүх.
 - E. Ихээр цус гарахгүй бол хүлээнэ.
- /92./ Гипотерми бүхий ховдлын тахикардийн үед хамгийн зөв эмчилгээг сонго:
- A. Прокаинамид
 - B. Лидокайн
 - C. Амiodарон
 - D. Атропин
 - E. Аденозин
- /93./ 32 настай эмэгтэй толгой эргэнэ, унах гээд байна гэсэн зовиуртай ирэв. Түүний зүрхний цохилтын тоо минутанд 186 байсан ба даралт нь 132/76мм МУБ байв. Түүний өвчний түүхэнд Волф-Паркинсон-Ваят синдром оношлогдож байжээ. ЗЦБ-т өргөн бүрдэлт хэм жигд бус ховдлын тахикарди мөн ховдлын экстрасистол бүртгэгдэж байв. Та ямар эмийг эмчилгээнд сонгох вэ?
- A. Аденозин
 - B. Пропранолол
 - C. Дилтиазем
 - D. Дигоксин
 - E. Прокаинамид
- /94./ Халдварын голомттой өвчтөнд доорхоос аль нь байвал үжлийн оношилгооны шалгуур болох вэ?
- A. Сийвэнгийн бикорбанат 16 мЭкв/дл
 - B. Цулын температур < 36°C
 - C. Амьсгалын тоо 18удаа/мин
 - D. Сийвэнгийн глюкоз < 60 мг/дл.
 - E. Ухаан санаа алдагдах
- /95./ Аортын хуулрал оношийг сэжиглэсэн үед
- A. 15% орчимд тохиолдолд ухаан алдалт илэрдэг
 - B. 5-аас цөөн хувьд мэдрэлийн талаас өөрчлөлт илэрдэг
 - C. Зүүн титмийг хамарсан ойрын хуулрал нь хамгийн түгээмэл ба ойролцоогоор 10% тохиолддог.
 - D. Аортын хуулрал нь 40-өөс доош насныханд тохиолдох нь ховор.

- Е. Мөчдийн пульсын зөрөө 30%-д тохиолддог.
- /96./ Ходоодны шарх болон гастритыг оношлох хамгийн чухал шинж аль нь вэ?
- А. Шөнөөр өвдөх
 - В. Хоол идэж чадахгүй болох
 - С. Хоол идсэний дараа өвдөлт ихсэх
 - Д. Хэрхрүүлэх
 - Е. Дотор муухайрах
- /97./ Цусны эргэлтийг шалгах анхны тусламжинд сонгох арга:
- А. Цээжийг чагнах
 - В. Хялгасан судасны эргэн дүүрэлтийг шалгах
 - С. Гүрээний артер дээр тэмтрэх
 - Д. Өвчтөн хяналтын монитор холбох
 - Е. Дээрх бүгд зөв
- /98./ 6 сартай хүүхэд яаралтай тусламжийн тасагт хоолоо муу идээд байна гэсэн зовиуртай ирэв. Хүүхэд орчиндоо харьцаа муу боловч өвтгөхөд хариу урвалтай байв. Захад лугшилт тэмтрэгдэхгүй, хяналтын мониторт ЗЦТ 250 нарийн бүрдэлт тахикарди байв. Хүүхдийн жин 8 кг. Таны авах арга хэмжээ
- А. Верапамилыг 0.1мг/кг аар судсаар аажим шахна
 - В. Дигоксиныг 0.02мг/кг аар судсаар хийх
 - С. Яаралтай кардиоверси 16Ж цохиулна
 - Д. Яаралтай кардиоверси 8Ж цохиулна
 - Е. Яаралтай дефибриллятоор 16Ж цохиулна
- /99./ Зөв гүйцэтгэж буй цээж шахалт нь цус эргэлтын хэдэн хувийг орлох вэ?
- А. 15%
 - В. 30%
 - С. 0.45
 - Д. 60%
 - Е. 85%
- /100./ Мелена:
- А. ХБДЗ-аас цус алдсан өвчтний 95% илэрдэг
 - В. Хоол боловсруулах замаас хамгийн багадаа 24 цагийн дотор алдсан цуснаас үүснэ
 - С. ХБДоод замын цус алдсан өвчтний гуравны нэгд илэрнэ
 - Д. Хоол боловсруулах замд 10мл хүртэл цус алдахад илэрнэ
 - Е. Цус алдалт зогссоны дараа 24 цагийн дотор хар болон цусархаг гарч болно
- /101./ Перикардитын талаарх зөв хариултыг сонго:
- А. Хамгийн түгээмэл илрэх шинж тэмдэг нь голт болон өвчүүний араар өвдөх ба босоход өвдөлт ихсэж түрүүлгээ харахад намддаг
 - В. Эмнэлэгт хэвтэхийг ихэвчлэн зөвлөх ба учир нь хамгийн их тохиолддог

вирусын перикардит нь амь насанд аюултай

С. Перикардит нь 12 холболт бүхий ЭКГ-д ST сегмент өргөгдсөнөөр баттай оношлогдоно

Д. Уламжлалт ар-өврийн хажуугийн байрлалаар авахуулсан рентген зургаар перикардитыг оношлоход хязгаарлагдмал байдаг

Е. Перикардийн шүргэлцэх чимээ нь нийт хүн амын дунд цөөн тохиолддог (5-7%) учраас энэ шинжээр цочмог перикардитыг оношлоход хязгаарлагдмал /102./ Лактулоза нь гэдэснээс аммонийн ионыг хэрхэн цэвэрлэдэг вэ?

А. Бүдүүн гэдэсний бактерийн нөлөөгөөр сүүний хүчил болж хувирч энэ нь өтгөнийг хүчиллэг болгож улмаар өтгөнд аммонийг шингээж гадагшилна

В. Аммонийг эсийн доторх мембраны натри-калийн шахуургаар нэвтрүүлж энэ нь трикарбосилик хүчлийн цикл оролцоно.

С. Бөөрөөр хлорын ялгаралтыг нэмэгдүүлж улмаар дасан зохицолын хэт амьсгалалт болон амьсгалын алкалоз болгох ба энэ нь аммонийг хоргүйжүүлдэг

Д. Гэдэсний хананд хамгаалах давхарга үүсгэж энэ нь аммонийг шимэгдэхээс сэргийлдэг

Е. Преаммони хэлбэртэй байх үед нь мицелжүүлэх ингэснээр хорт хэлбэрт шилжихээс сэргийлнэ.

/103./ Комбитуби нь:

А. Амьсгалын зам чөлөөлөх эхний сонголт болдог хэрэгсэл

В. Эмнэлэгт амьсгалын зам чөлөөлөхөд хэрэглэнэ

С. Амьсгалын зам чөлөөлөхөд төвөгтэй үед хэрэглэдэг нөөц хэрэгслүүдийн нэг

Д. Ихэвчлэн цагаан мөгөөрсөн хоолойд байрладаг

Е. Зөв тавигдсан эсэхийг капнометрээр хэмжих боломжгүй учир нь уг хэрэгсэлтэй холбогддоггүй

/104./ 39 настай эмэгтэй шингэн зүйл залгихад горойх болон өмхий хэрхрүүлнэ гэсэн зовиуртай ирэв. Тэрээр хэд хоногийн өмнө тодосгогчтэй бодис залгиж рентген зураг авхуулахад улаан хоолой тэлж өргөссөн, доод хэсгээрээ огцом нарийсаж хаагдсан байсан бол та ямар өвчнийг сэжиглэх вэ?

А. Улаан хоолойн колик

В. Улаан хоолойн хавдар

С. Рефлюкс эзофагит

Д. Склеродерма

Е. Ахалази

/105./ ЯТТ-т цөсний гиваан гэж сэжиглэсэн өвчтний хамгийн түрүүнд хийх дүрс оношилгооны шинжилгээ?

А. Хэвлийн рентген зураг

В. Хэвлийн эхо

С. Хэвлийн КТГ

- D. Цөмийн онош зүй
 - E. Бари уулгаж зураг авах
- /106./ HELLP хам шинжийн үед доорхоос аль нь орохгүй вэ?
- A. Аюулхайд өвдөх, дотор муухайрах, бөөлжих
 - B. Тромбоцит 100,000/mL доош буух
 - C. Шээсэнд уураг илрэх
 - D. 10% кальци глюконат хийх
 - E. АД ихсэлт бол оношилгооны түлхүүр
- /107./ Сукцинилхолин нь:
- A. Катехоламины ялгаралтыг ихэсгэж синусын тахикардиг үүсгэнэ
 - B. Түлэгдсэн өвчтөнд хэрэглэхэд амь насанд аюултай гиперкалемиг үүсгэнэ
 - C. Булчингийн төгсгөлд байрлах ацетилхолины рецептортой өрсөлдөх байдлаар холбогдсоноор үйлдэл ихсэнэ
 - D. Холинэстеразагийн идэвхи буурсан хүмүүс болох элэгний өвчтэй болон жирэмсэнд хэрэглэхээс зайлхийх хэрэгтэй.
 - E. Тасалгааний нөхцөлд 3-аас дээш сар хадгалахад 90-ээс дээш хувийн идэвхээ хадгалж чаддаг.
- /108./ Анхан төрөгчид төрлөгийн I үе нь дунджаар хэдэн цаг үргэлжлэх вэ
- A. 3-5 цаг
 - B. 6-9 цаг
 - C. 10-14 цаг
 - D. 15-18 цаг
 - E. 19-24 цаг
- /109./ Цээжээр өвдсөн, зэргэлдээ 2 холболтонд ST>1мм-ээс дээш өргөгдсөн, тропонин өсөөгүй бол аль нь байж болох вэ
- 1. Титмийн цочмог хам шинж
 - 2. Улаан хоолойн урагдал
 - 3. Уушигны хатгалгаа
 - 4. Зүрхний цочмог шигдээс
 - 5. Цээжний гялтан хальсны үрэвсэл
- /110./ Нярай хүүхдийн анхны үнэлгээнд юу орох вэ?
- 1. Булчингийн тонус
 - 2. Амьсгал
 - 3. Зүрхний цохилтын тоо
 - 4. Арьсны өнгө
 - 5. Уйлах
- /111./ ТСЦХШ сэдээх хүчин зүйлс :
- 1. Дасгал хөдөлгөөн
 - 2. Сэтгэлийн хүчтэй цочрол
 - 3. Яаралтай мэс заслын болон бусад цочмог эмгэгүүд

4. Өглөө /сэрсэний дараах хэдэн цагт/
 5. Өвөл хүйтэн агаар амьсгалхад
- /112./ Аалзан бүрхэвчийн доорх цусан хураатай (САК-тай) өвчтөнгүүдэд түгээмэл тохиолддог эмнэлзүйн гол шинж аль нь вэ?
1. Уушиг хавагнах
 2. Толгой гэнэт хүчтэй өвдөх
 3. Нүд хялар болох
 4. Тархины зөөлөн бүрхүүлийн цочролын шинж
 5. Хурхирах
- /113./ Крикотериодтомиг аль түвшинд хийх вэ?
1. Бөгж мөгөөрсний доор зүснэ
 2. Бамбай мөгөөрсөн дээр зүснэ
 3. Цагаан мөгөөрсөн хоолойн 2,3 мөгөөрсний завсар зүснэ
 4. Бамбай мөгөөрс, бөгж болон хооронд зүүгээр хатгах эсвэл зүслэг хийж агаар оруулах ажилбар
 5. Өвчүүний бүдэрхийн дээгүүр
- /114./ Мориноос тонгорч унасан ухаангүй хүнд таны нэн түрүүнд үзүүлэх тусламж юу вэ?
1. Өргөж байгаад сэгсэрнэ
 2. Амьсгалын замыг чөлөөлж амьсгал өгнө
 3. Цээжинд шахалт хийнэ
 4. Хүзүүний бэхэлгээ хийж амьсгалын зам чөлөөлнө
 5. Тусламж дуудна
- /115./ Уушигны хавангийн бүрдмэл эмчилгээнд хамаарагддаг аргуудыг сонгоно уу?
1. 30% O₂, 70% гелигээр амьсгалуулах
 2. Хошуувчаар зохиомол амьсгал хийх
 3. Амьсгал гаргалтанд эерэг даралттай зохиомол амьсгал хийх
 4. Морфин хэрэглэх
 5. Лазикс хэрэглэх
- /116./ 100%-ийн O₂ –өөр хэдэн цаг амьсгалуулхад O₂ хордлого үүсч болох вэ?
1. Хордлого үүсдэггүй
 2. Хэдэн цагаар ч өгч болно
 3. 12 цаг хүртэл
 4. 24 цагаас дээш
 5. 12 цагаас дээш
- /117./ Доорхоос гипоксийн хэлбэрт хамаарагддаг нь
1. Амьсгалын
 2. Цус эргэлтийн
 3. O₂ хэмжээ буурах

4. Амьсгаадах
 5. Хөлрөх
- /118./ Та энэ ЗЦБ-с юуг олж харж байна вэ?
1. Шовх Т шүд
 2. Эмгэг Q шүд
 3. R шүдний өндөр буурсан
 4. Зэргэлдээ 2 холболтонд $ST > 1$ мм өргөгдсөн
 5. QT хэрчим уртассан
- /119./ Цус харвалтын төрлүүдийг дугуйл:
1. Судасны үрэвслийн
 2. Цус хомсдлын
 3. Төрөлхийн
 4. Судас хагарлын
 5. Тархины үрэвслийн
- /120./ Ам залгиурын агаар дамжуулах гуурсны хэмжээг сонгох
1. Үүдэн шүднээс чихний омог хүртэл
 2. Амнаас төвөнх хүртэл
 3. Үүдэн шүднээс хэлний уг давтал
 4. Үүдэн шүднээс эрүүний өнцөг хүртэл
 5. Хамарны үзүүрээс чихний омог хүртэл
- /121./ Хүүхдийн ухаан санааны байдлыг хэрхэн үнэлэх вэ?
1. AVPU
 2. Глазго үнэлгээ
 3. TMC-ийн үнэлгээ
 4. Хүүхдийн насанд тохирсон сэтгэц хөдөлгөөний үнэлгээ
 5. Дээрхи бүгд зөв
- /122./ Хоёр хөлийн шилбэний хугаралтай шокийн байдалтай өвчтөнг эмнэлэгт хүргэхийн тулд зайлшгүй авах арга хэмжээ нь:
1. Цус алдалтыг зогсоох
 2. Хөдөлгөөнгүй бэхлэх
 3. Хөлийг өндөрлөх
 4. Шингэн сэлбэх
 5. Өвдөлт намдаах
- /123./ Презклампси нь
1. Голдуу жирэмсний 32 дахь долоо хоногоос илэрнэ
 2. Архи уудаг эмэгтэйд илүү илэрнэ
 3. Чихрийн шижинтэй эмэгтэйд илүү тохиолдоно
 4. Хавагнах, шээсээр уураг алдах, даралт ихсэх
 5. Бүх жирэмсэн эхэд тохиолдоно
- /124./ Амьсгалын үйл ажиллагаа алдагдалтайг ямар шинжээр мэдэх вэ?
1. Хамар сарталзах

2. Толгой дохилзох
 3. Амьсгалын доод замын бөглөрөл
 4. Цээж хонхолзох
 5. Амьсгалын дээд замын бөглөрөл
- /125./ O₂-н цочмог хордлогын үед ямар эмнэлзүйн шинжүүд илрэх вэ?
1. Хөхрөх
 2. Өвчүүний цаана өвдөх
 3. Илэрхий шинж тэмдэг байдаггүй
 4. Хуурай ханиалгах
 5. Царай улайх
- /126./ Эпилепсийн таталтын үед доорх эмүүдээс алийг нь хэрэглэх вэ?
1. Дроперидол 0.025%-1 мл тарих
 2. Магни В6 уух
 3. Магnezм 25%-10мл булчинд тарих
 4. Диазепам 10мг судсаар
 5. Амитриптиллин 25 мг уух
- /127./ Анафилаксийн шокийн үеийн эмчилгээний эхний сонголт:
1. Кальци хлорид
 2. Димедрол
 3. Дексаметазон
 4. Адерналин
 5. Анальгин
- /128./ Та онош тодруулахын тулд та ямар шинжилгээнүүдийг төлөвлөх вэ?
1. Зүрхний өвөрмөц энзимүүд
 2. ЭХОКГ
 3. Ангиографи /титэм судсан дотуурх шинжилгээ/
 4. ЭКГ
 5. Рентген, ЭХО
- /129./ Энэ шокийн үеийн яаралтай тусламж:
1. Допамин
 2. Парасимпатикийг цочроох эмчилгээ
 3. Дигоксин
 4. Кордарон
 5. Атропин
- /130./ Судас ба ясанд эхлээд хийх шингэн, хэдээр хийх вэ?
1. Натрий хлорид
 2. 20мл/кг тооцно
 3. 2 удаа давтана
 4. 10мл/кг тооцно
 5. Ижил бүлгийн цус
- /131./ Цохиулах шаардлагагүй хэмд ямар хэм орох вэ?

1. Ховдлын фибрилляци
 2. Пульсгүй цахилгаан идэвхижил
 3. Ховдлын тахикарди
 4. Асистола
 5. Суправентрикуляр тахикардия
- /132./ Хүүхдэд зүрх зогсоход хүргэх шалтгаан юу вэ?
1. Гипокси
 2. Гиповолеми
 3. Гиперкалеми /гипокалеми/эрдэс
 4. Гипотерми /гипертерми
 5. Хордолт
- /133./ Зүрх зогсолтын ямар хэмнэлийг дефибрилятоор цохиулах вэ?
1. Агшилтгүй болох
 2. Ховдлын жирвэлзэл
 3. Лугшилтгүй цахилгаан идэвхжил
 4. Ховдлын тахикарди лугшилтгүй
 5. Тосгуурын жирвэлзэл
- /134./ Чинэрэлт пневмотораксын үед нэн түрүүнд ямар арга хэмжээ авч болох вэ?
1. Зохиомол амьсгал хийх
 2. Цээжний хөндийг нээлттэй болгох
 3. Бронх өргөсгөгч
 4. Эгэмний дунд шугамаар II-III-р хавирга завсраар хатгалт хийх
 5. Хэвлийн хөндийд хатгалт хийх
- /135./ Баруун ховдлын шигдээсийг ЗЦБ-ийн өвөрмөц шинж
1. V4 ST өргөгдөх
 2. V1, V2, AVR ST өргөгдөх
 3. AVL-т ST өргөгдөх
 4. V4 R ST өргөгдөх
 5. V4 ST буух
- /136./ CABD гэж юу вэ?
1. Дефибрилляци, амьсгал
 2. Цус эргэлт, амьсгалын зам чөлөөлөх
 3. Цус эргэлт, дефибрилляци
 4. Амьсгал өгөх, дефибрилляци
 5. Амьсгалын зам чөлөөлөх амьсгал өгөх
- /137./ Амилуулах лавшруулсан тусламжинд хэрэглэх гол эм:
1. Лидокайн
 2. Дигоксин
 3. Атрофин
 4. Адреналин

5. Кальци хлорид
- /138./ Амилуулах суурь тусламжийг хэдий хүртэл үргэлжлүүлэх вэ?
1. Мэргэшсэн тусламж ирэх хүртэл (дефибриллятортай)
 2. Тусламж авагч нас барсан нь тодорхой болсон
 3. Үргэлжлүүлэх боломжгүй болсон (ж: туйлдах)
 4. Өвчтний зүрх сэргэсэн
 5. Бүгд зөв
- /139./ Гипокси болж байгаа үед хамгийн түрүүнд ямар эмнэлзүйн шинж илрэх вэ?
1. Амьсгаадах
 2. Зүрх дэлсэх
 3. Бие тавгүйтэх
 4. Хөлрөх
 5. Амьсгал цөөрөх
- /140./ O₂ эмчилгээний заалтанд та юуг ойлгож байна вэ?
1. 21% O₂ амьсгалах шаардага гарах
 2. Цээжээр хөндүүрлэх үед
 3. Амьсгалын тоо олширсон үед
 4. Тасалгааны агаараар амьсгалхад O₂ хэрэглэх шаардлага гарах
 5. O₂ 94%-аас доош буух
- /141./ Цус эргүүлэгийн хямралыг эмнэлзүйн ямар шинжээр үнэлэх вэ?
1. Даралт 60-с доош болох
 2. Арьс цайх
 3. Арьс ягаарах
 4. Арьс эрээнтэх
 5. Дээрхи бүгд зөв
- /142./ Тархи нугасны шингэнийг хэдийд шинжлэх вэ?
1. Менингийн шинж илэрсэн үед
 2. КТГ хийсний дараа
 3. Цус харваснаас хойш 12 цагийн дараа
 4. Онош тодруулах зорилгоор
 5. Тархи, нугасны хөндийн даралтыг хэмжих зорилгоор
- /143./ Амилуулах тусламжинд кордарон хэрэглэх заалт юу вэ?
1. Цахилгаанаар цохиулахад засрахгүй ховдлын жирвэлзлийн үед
 2. Ховдлын жирвэлзлийн дахих хэлбэр
 3. Дефибрилляцид тэсвэртэй тахикарди
 4. Ховдлын жирвэлзлийн үед
 5. Лугшилтгүй цахилгаан идэвхжил
- /144./ Лугшилтгүй цахилгаан идэвхжил гэдэг нь
1. P шүдгүй байх
 2. Захад судасны лугшилт тодорхойлогдохгүй

3. QRS бүрдлээс илүү олон P шүдтэй
 4. мониторт цахилгаан идэвхжил илэрнэ
 5. Монитор зүрхний цохилт маш хурдан захад судасны лугшилттай
- /145./ Бүлэн уусгах эмчилгээний эмнэлзүйн заалт:
1. БУЭ-ний бэлдмэлд эсрэг заалтгүй байх
 2. Эмнэлзүйн шинж тэмдэг эхлээд 12 цаг болоогүй байх
 3. ЗЦБ-н зэргэлдээ 2 холболтонд ST сегмент 1мм-с илүү өргөгдсөн
 4. Цээжээр өвдсөн, ST сегмент өргөгдөөгүй, тропонин өссөн
 5. Q шүд >0.02 с V2-V3 холболтуудад илрэх
- /146./ Дээрх тохиолдолд эмчилгээнд сонгох нь:
1. МОНА эмчилгээ
 2. Бүлэн уусгах эмчилгээ
 3. Титэм судсан дотуурх эмчилгээ
 4. Антикоагулянт
 5. Бетта хориглогч
- /147./ Нярай хүүхдэд хийх адерналин тун хэд вэ?
1. 0.1 мл/кг
 2. 1:10000
 3. 1:10000
 4. 0.1-0.3 мл/кг
 5. 1;1000
- /148./ O2 эмчилгээний хэрэгслүүдийг хэрхэн сонгох вэ?
1. Өөрөө бодож байгаад
 2. Өөрт нь аль эвтэйхэнээр
 3. Амьсгалын тооноос хамаарч
 4. O2 хэрэгцээнд тулгуурлан, SpO2-92% доош буулгахгүй
 5. эмнэлзүйд тулгуурлан
- /149./ Хүн ухаангүй байна доорх алхамын аль нь зөв вэ?
1. Аюул шалгаж зайлуулах
 2. Энгийн тушаал өгч, дуудан амьсгал шалгах, тусламж дуудах
 3. Цээжинд шахалт хийх
 4. Амьсгалын зам чөлөөлөх, амьсгал өгөх
 5. Автомат тохируулгат дефибриллятор хэрэглэх
- /150./ Зүрх зогсолтын ямар хэмнэлийг дефибрилятоор цохиулахгүй вэ?
1. Ховдлын жирвэлзэл
 2. Агшилтгүй болох
 3. Тосгуурын савчаа
 4. Лугшилтгүй цахилгаан идэвхжил
 5. Ховдлын тахикарди лугшилтгүй
- /151./ Нярай хүүхдийн зүрхний иллэг хийх ямар аргууд байдаг вэ?
1. Нэг гарын арга

2. а. Эрхий хурууны арга
3. а. Хоёр гарын арга
4. а. Хоёр хурууны арга
5. а. Дээрхи бүгд зөв

/152./ Титэм судас бөглөрч тэлэгч тавьсаны дараа ямар эмийг зөвлөх вэ?

1. Клопидогрел
2. Аспирин
3. β -хориглогч
4. Варфарин
5. Фуросемид

/153./ Үнэрлэх байрлал гэж:

1. Толгойг дээд зэргээр гэдийлгэх
2. Толгой доор дэр тавих
3. Толгой доор дэр тавих шаардлагагүй
4. Толгойг гэдийлгэнэ
5. Толгойг гудайлгах

/154./ Хүүхдийн гадаад байдлыг үнэлэх

1. Хөдөлгөөний идэвхи
2. Ухаан санааны байдал
3. Тайвшрах байдал
4. Нүүр рүү тогтвортой харах
5. Уйлах

/155./ Зүрх жирвэлзэж зогсох үед дефибрилятораар хэдэн Джоулаар цохиулах вэ?

1. Монофазтай бол 250J ,300J,360J
2. Фаз хамаарахгүй Хүүхдэд : 250 J, том хүнд 350J
3. Бифазтай бол 120J цохиулаад ахиулна
4. Бифазтай бол 200J, монофазтай бол 360 J -аар цохиулах
5. 100 J аас эхлэн ахиулан цохиулна

/156./ O₂-н цочмог хордлогын үед ямар эмгэгүүд үүсдэг вэ?

1. Уушиг хатуурах
2. Трахейбронхит
3. Уушгины хатгалгаа
4. амьсгалын гачаалт хамшинж
5. Гуурсан хоолойн багтраа

/157./ Артерийн даралт маш өндөр болсон үед яаралтай буулгахын тулд доорхоос

1. Атенолол 25 мг уух
2. Каптоприл 25 мг уух
3. Фуросемид 10 мг тарих
4. Нифедипин 10 мг уух

5. Гипотиазид 25мг уух
- /158./ Хүүхдийг үнэлэх гурвалжинд юу орох вэ?
1. Гадаад байдал
 2. Амьсгалын үйл ажиллагаа
 3. Цус эргүүлэг
 4. Шокийн байдал
 5. Оврого үнэлэх
- /159./ Үжлийн шокийн талаарх зөв ойлголтыг сонгоно уу
- А. Грам эерэг бактериуд нь үжлийн шок үүсгэдэггүй учир нь тэд эсийн ханын эндотоксиноор дутмаг
- В. Лейкопени нь үжлийн шокийн шинж биш
- С. Грам сөрөг бактери болох түгээмэл шалтгаанаас хоёрдугаарт бөөр шээсний замаас үүссэн байдаг
- Д. *Escherichia coli* нь грам сөрөг бактери болох хамгийн түгээмэл тохиолддог 2 дахь үүсгэгч юм
- Е. Грамм сөрөг эндотоксины хорны нөлөө нь хэвийн физиологийн урвалыг эмгэг болгох байдаг
- /160./ Улаан хоолойн перфораци үүсэх ихэнх тохиолдол нь:
- А. Аяндаа үүснэ
 - В. Ятрогеник
 - С. Гэмтлийн
 - Д. Идэмхий шингэн залгисанаас
 - Е. Идиопатик
- /161./ Перикардийн тампонад бүхий өвчтөнд хянаж байхдаа дараахаас аль шинж нь аюултай вэ?
- А. Зүүн ба баруун ховдлын даралт тэнцүү болох
 - В. зөвхөн систолийн гипертензи
 - С. Цээжинд пульсаци ажиглагдана
 - Д. 12 холболт бүхий ЗЦБ-т R шүд намхан бичигдэнэ
 - Е. Митрал регургитаци
- /162./ Бөөлжиж, чацга алдсан үед судсаар сэлбэх үндсэн шингэн болгон сонгон авах уусмал?
- А. Маннитол
 - В. 8,4%-ийн содын уусмал
 - С. Рингерийн уусмал
 - Д. 5% глюкоз
 - Е. Дескран
- /163./ 62 настай эмэгтэй ухаангүй ЯТТ ирэв. Тэрээр өвтгөхөд цочрох бөгөөд Глазго комын үнэлгээ 11 бал байв. Артерын даралт нь 100/60мм МУБ ба ЗЦТ нь 100 байв. Үзлэг хийхэд хялгасан судасны эргэн дүүрэлт буурсан ба арьс салст хуурай байв.ЗЦБ-т QT интервал нь богино. Лабораторын шинжилгээнд

сийвэнгийн кальци 14.2мг/дл, фосфор 2.9мг/дл, кали 3.9мЭв/л, креатинин 1.9мг/дл байв. Таны эхний эмчилгээний сонголт юу вэ?

- A. Магний сульфат 2мг –аар судсаар аажим хийнэ.
- B. Памидронат 60мг судсаар
- C. Кальцитонин 4 IU/кг
- D. Шингэн сэлбэсний дараа фуросемид 60 мг судсаар
- E. Яаралтай гемодиализ

/164./ Нэг удаагийн амьсгалын тохирсон эзэлхүүн:

- A. 500-600 мл орчим
- B. Биеийн жингээс хамаарна
- C. Наснаас хамаарна
- D. 6 мл/кг тооцно
- E. Өндрөөс хамаарна

/165./ Ходоодонд хаймсуур тавихад доорх тохиолдлын алинд нь эсрэг заалттай вэ?

- A. Улаан хоолойн цоорол сэжиглэсэн үед
- B. Улаан хоолойн цоорол батлагдсан үед
- C. Улаан хоолойн венийн өргөслийн асуумжтай
- D. Улаан хоолойн хавдартай
- E. Улаан хоолойд гадны биет байгаа

/166./ 45 настай эрэгтэй яаралтай тусламжийн тасагт биеийн 40% нь түлэгдсэн байдалтай ирсэн. Түүний биеийн жин ойролцоогоор 80кг бол хичнээн хэмжээний рингер лактатын уусмал эхний 8 цагт сэлбэх вэ?

- A. 4400mL
- B. 5400mL
- C. 6400mL
- D. 7400mL
- E. 8400mL

/167./ Зүрхний эмгэг болон архины талаарх зөв ойлголтыг сонго:

- A. Архины архаг хэрэглээ нь рестриктив кардиомиопати үүсгэж болно
- B. Хэрвээ зүрхний дутагдал үүссэн тохиолдолд архи уухаа зогсоосон ч тавиланг өөрчилж чадахгүй
- C. Зүрхний төрөлхийн дутагдал нь тиамины дутагдлаас үүсдэг
- D. Хэрвээ архины шалтгаант кардиомиопатитай өвчтөн архи уухаа үргэжлүүлээд байвал нас барах нь 3 жилийн дотор 70% их байдаг
- E. Дээрхи бүгд зөв

/168./ Гемморагийн шоктой өвчтөнд авах эхний арга хэмжээ?

- A. Коллойд шингэнг хурдан сэлбэнэ
- B. Хангалттай хэмжээгээр хүчилтөрөгч болон амьсгалаар хангана
- C. Гемодинамикийг тогтвортой барихын тулд инотропик эхлэнэ
- D. Бүх урт ясны хугаралыг тогтворжуулна

- Е. Бүлэг тохироогүй ч цус яаралтай сэлбэнэ
- /169./ Төрлөгийн үед PV–г ямар зорилгоор хийх вэ
- А. Ургийн шингэний хальс бүтэн эсэхийг
 - В. умайн хүзүүний нээгдэлтийн байдал
 - С. Ургийн толгойн тавилт
 - Д. Аарцаг ясны хэмжээ болон ургийн байдалд дүгнэлт өгөх
 - Е. Бүгд зөв
- /170./ Цээжээр өвдөх шинж тэмдэг эхэлсэнээс хойш ТСДЭ-г хэдий хугацаанд хийх вэ?
- А. 90 мин
 - В. 180 мин
 - С. 12 цаг
 - Д. 30 цаг
 - Е. 24 цаг